



# МОНГОЛ

НҮБ-ын Хүн амын сангийн

**2016 оны тайлан**





# МОНГОЛ УЛАСЫН НҮБ-ЫН ХҮН АМЫН САНГИЙН

НҮБ-ын Хүн амын сангийн  
**2016 оны тайлан**



# ГАРЧИГ

<b>Өмнөх үг</b>	<b>7</b>
<b>Суурин төлөөлөгчийн мэндчилгээ</b>	<b>8</b>
<b>Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх</b>	<b>10</b>
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг цогцоор нь хуульчлахад санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг үзүүлэв	10
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогыг боловсруулахад хамтран ажиллав	11
Телемедицин төслийн үйл ажиллагаа	11
Эх, нярайн эрүүл мэндийг цаашид сайжруулахыг зорьж байна	12
Хилийн дагуух бүс нутагт БЗДХ-аас урьдчилан сэргийлэх төслийг БНХАУ-тай хамтран хэрэгжүүлж дууслаа	13
<b>Жендэр</b>	<b>14</b>
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах үйл явц	14
Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх шинэ төслийг Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж эхлэв	15
Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хууль боловсруулах нөхцөлийг бүрдүүлэв	16
Гамшгийн үед ариун цэвэр эрүүл ахуйн багц түгээв	16
<b>Залуучууд</b>	<b>18</b>
Залуучуудын цогц бодлого боловсруулахыг зорьж байна	18
Монголын залуучуудыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээгээр хангаж байна	20
Амьдрах ухааны боловсрол	21
<b>Хүн амын тоон мэдээ, мэдээлэл</b>	<b>23</b>
Хүн ам, хөгжлийн талаар хууль боловсруулахад дэмжлэг үзүүлэв	23
Өнөөгийн нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг шийдвэрлэхэд шаардлагатай тоон мэдээ, мэдээлэл цуглуулав	23
<b>Менежментийн үр дүн</b>	<b>24</b>
Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэв	24
Хөрөнгө, нөөц дайчлав	26
НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ болон улс орныг дэмжих 6 дахь хөтөлбөр	27
Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусав	27
Захиргаа, санхүүгийн үр ашигтай үйл ажиллагаа	27
Нэгдмэл дуу хоолой	28
<b>Санхүүгийн товч тайлан</b>	<b>29</b>



# ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хүн амын сангаас Монгол улсад дэмжлэг үзүүлэх 5 дахь хөтөлбөрөө 2012-2016 онд амжилттай хэрэгжүүлж дууслаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлж дууссан он цаг нь Монгол улсыг Мянганы хөгжлийн зорилтууд (МХЗ-ууд) ялангуяа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг тэгш эрхээр хангах Мянганы хөгжлийн 3 дахь зорилт, эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн 5 дахь зорилт, ХДХВ/ДОХ-той тэмцэх Мянганы хөгжлийн 6 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд 10 жилийн турш дэмжлэг үзүүлж дууссан цаг үетэй давхцан тохиов. Монгол улс эхийн эндэгдлийг 2/3-оор бууруулах зорилтдоо 2015 онд амжилттай хүрсэн дэлхийн 9-хөн орны нэг болж чадлаа.

МХЗ-уудаа амжилттай хэрэгжүүлж, өөр бусад мэдэгдэхүйц ололт амжилтад хүрсэн Монгол улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээр баталсан тогтвортой хөгжлийн зорилтуудыг 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр шийдэж, хөгжлийн шинэ эринг эхлүүлэв. Монгол Улсын Их хурал 2030 он хүртэл хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхээр шийдсэнээ 2016 оны 2-р сард баталгаажуулсан юм. 2016 оны 9-р сард Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан бөгөөд энэ нь Засгийн газрын амлалт бүхий тогтвортой хөгжлийн зорилтууд болон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан хөтөлбөр юм.

НҮБ-ын Хүн амын сан болон Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн 40 гаруй жилийн хамтын ажиллагаандаа тулгуурлан, зорилго зорилтуудаа шинэчлэхийн сацуу 2016 онд тодорхой үр дүнд хүрэхээр тасралтгүй хамтран ажиллалаа. Амжилттай хамтран ажилласны үр дүнд Телемедициний сүлжээгээр дамжуулан эх нярайн эрүүл мэндийг сайжруулахад ахиц гаргаж, зан үйлд нөлөөлөх замаар эхийн эндэгдэл, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ыг бууруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх эмзэг бүлгийнхний мэдлэгийг дээшлүүлж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 оны 12-р сард батлахад дэмжлэг үзүүлж, Монголын залуучуудад амьдрах ухааны боловсролыг улам хүртээмжтэй болгов.

НҮБ-ын Хүн амын сан нь жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд, залуу хүн бүр нөөц бололцоогоо бүрэн дайчилж, хөгжлийн өндөрлөгт хүрэх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг. Энэхүү зорилтыг Монголд хэрэгжүүлэхийн төлөө НҮБ-ын Хүн амын сан Монгол Улсын Засгийн Газар, иргэний нийгэм, төдийгүй Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газар, Оюу толгой ХХК зэрэг хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

# I. СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ



2016 он Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн хувьд ихээхэн эрч хүчтэй хэрнээ тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх хөгжлийн шинэ эринд шилжсэн дэлхий дахины эрэлт хэрэгцээ, тулгамдсан асуудлуудад нийцүүлэн шилжилт хийсэн чухал жил байлаа.

Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрийг 2012-2016 онд амжилттай хэрэгжүүлж дуусав. Дэлхий дахинаа 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр шийдсэн тогтвортой хөгжлийн зорилтууд дээр өөр бусад хөгжлийн зорилтуудыг нэмж 2016 онд Монголд хэрэгжүүлж эхлэв. 2016 онд мөн Нью-Йорк дахь НҮБ-ын Хүн амын сангийн захирлуудын зөвлөл тус сангаас Монгол улсад дэмжлэг үзүүлж

2017-2021 онд хэрэгжүүлэх 6 дахь хөтөлбөрийг баталж, уламжлалт хандивлагчид болох Швейцарийн хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газраас гадна Оюу толгой ХХК, Монголын хэвлэлийн хүрээлэн, Монгол дахь JCI байгууллага, Гурван билэг ХХК зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай шинээр түншлэлийн харилцаа тогтоов.

2016 онд гарсан аливаа өөрчлөлтөөс үл хамааран НҮБ-ын Хүн амын сан 1970-аад оноос эхлүүлсэн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, хөгжлийн чиглэлээр Монгол улсын чухал түнш хэвээр байж, “жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд, залуу хүн бүр нөөц бололцоогоо бүрэн дайчилж, хөгжлийн өндөрлөгт хүрэх нөхцөлийг бүрдүүлэх”-ийг зорьж, тэргүүлэх чиглэлийнхээ хүрээнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, залуучуудын оролцоо, хөгжил, жендэрийн тэгш байдлыг хангахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

2016 онд НҮБ-ын Хүн амын сан Монгол улсад бусад дундаж орлоготой орнуудын нэгэн адил бодлого, ухуулга нөлөөллийн чиглэлээр үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж, тус сангийн тэргүүлэх чиглэлээр бодлого, эрх зүйн хүрээг бий болгохын тулд УИХ, чиглэлийн яамд, иргэний нийгмийн байгууллага, үндэсний болон олон улсын түншүүдтэй нягт хамтран ажиллав. Эх хүүхдийн эрүүл мэндийн тухай хууль, Залуучуудын хөгжлийн тухай хууль, Залуучуудын бодлого, Залуучуудын хөгжлийн үндэсний бодлогыг боловсруулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийг батлуулахад НҮБ-ын Хүн амын сан санхүүгийн болон техник арга зүй, ухуулга нөлөөллийн дэмжлэг үзүүлэв.

2015 онд Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн зорилтод хүрсэн дэлхийн 9-хөн орны нэг болж байсан ч энэ амжилтаасаа 2016 онд ухарсан нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн салбарт ихээхэн хүнд жил байлаа. Иймд нөхцөл байдал, хэрэгцээг шуурхай үнэлж, НҮБ-ын Хүн амын сангийн тусламж, улсын төсвийн санхүүжилтыг ашиглан Монголын залуучуудын гэр бүл төлөвлөлтийн хангагдаагүй хэрэгцээг хангаж, хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор



жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгсэлийг яаралтай ханган нийлүүлж, үүнд төсвөөс хангалттай хөрөнгө хуваарилуулах зорилгоор УИХ, Засгийн газар, хөгжлийн түнш байгууллагуудын удирдах түвшинд ухуулга нөлөөлөл хийв.

Залуучуудын хөгжлийн салбарт, Швейцарийн хөгжлийн агентлаг, Оюу толгой, Люксембургийн Засгийн газартай 2016 онд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэв. Мөн Өмнөговь аймгийн Ханбогд, Замын Үүд суманд өсвөр үе, залуучуудад ээлтэй клиникийг шинээр байгуулж, одоо улс орон даяар залуучуудад ээлтэй нийт 21 клиник ажиллаж байна. НҮБ-ын Хүн амын сан амьдрах ухааны боловсролыг дэмжиж, залуучуудын амьдрал, хөдөлмөр эрхлэлтэд шаардлагатай “хувь хүний ур чадварууд”-ыг залуучуудын хөгжлийн 16 төв, дунд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд байгуулсан амьдрах ухааны танхимуудаар дамжуулан илүү олон залууст олгоход үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэв.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулахад чиглэсэн томоохон ухуулга нөлөөлөл, сурталчилгааны үйл ажиллагаануудыг НҮБ-ын Хүн амын сан дэмжиж ажиллаа. НҮБ-ын Хүн амын сангаас зохион байгуулдаг “Orange Sessions” буюу улбар шар арга хэмжээнд Монголын залуу уран бүтээлчид уламжлал ёсоор оролцож, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох НҮБ-ын НЭГДЭЦГЭЭЕ аянаас зохион байгуулсан олон улсын дуу хөгжмийн уралдаанд “Orange the World” буюу эх дэлхийг улбан шар болгоцгооё дууг хамтдаа зохиож оролцов. Тэд мөн концертоороо дамжуулан олон нийтээс хандив цуглуулж, уг хандивыг НҮБ-ын Хүн амын сангаас дэмждэг нэг цэгийн үйлчилгээний 6 төвөөр үйлчлүүлсэн хүчирхийлэлд өртөгсдөд зарцуулав. Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийг 2016 онд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ төслийн хүрээнд тус улсын жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх тоон мэдээ, мэдээллийг цуглуулах чадавхийг сайжруулж, сургалтын аян зохион байгуулж, хүчирхийлэлд өртөгсдөд цогц үйлчилгээг үр өгөөжтэй үзүүлэх замаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. 2016 он бол тус улсад зуд (олон малчин өрх зуданд өртсөн юм) нүүрлэсэн ихээхэн хүнд жил байсан бөгөөд НҮБ-ын Хүн амын сан зуданд өртсөн охид, эмэгтэйчүүд түүний дотор жирэмсэн эхчүүдэд цаг алдалгүй тусалж, ариун цэвэр эрүүл ахуйн багц түгээв. Мөн гамшгийн үед охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээг хангахад анхаарч ажиллахыг НҮБ-ын Хүн амын сан үндэсний болон олон улсын түншүүддээ тасралтгүй ухууллаа.

2016 онд бид бүх зорилтоо хэрэгжүүлж томоохон амжилтанд хүрсэн билээ. Өнгөрсөн жил улс орныг дэмжих 6 дахь хөтөлбөр батлагдаж, бид бүхэн үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд өсвөр үе, залуучуудын асуудлыг түлхүү чухалчилж, ялангуяа бэлгийн цогц боловсрол, залуучуудад ээлтэй бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, жендэрийн тэгш байдлыг хангаж, охид, эмэгтэйчүүд түүний дотор хамгийн эмзэг бүлгийнхнийг эрх мэдэлжүүлж, чадавхижуулахад гол анхаарлаа хандуулна. Нэг ч хүнийг түүний дотор нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхнийг ардаа орхилгүй хөгжих зарчимд тулгуурласан улс орныг дэмжих 6 дахь хөтөлбөрт НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүлэх чиглэл гол байр суурь эзэлж байна.

Монгол улс Тогтвортой хөгжлийн зорилтууддаа хүрнэ гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд бид бүхэн улс орныг дэмжих шинэ хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлж, уламжлалт болон шинэ түншлэлийн харилцаагаа бэхжүүлэн, охид, эмэгтэйчүүд, залуучуудыг дэмжих замаар дэлхийн шинэ зорилтуудад хүрэхээр хичээнгүйлэн зүтгэх болно.

Бидэнд үргэлж итгэж, дэмжиж ажилласанд баярлалаа. 2016 онд эдгээр амжилтуудад хүрэлгүйгээр цаашдын зорилтуудад хүрэх боломжгүй юм.

**Наоми Китахара**  
*Суурин төлөөлөгч*

## II. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЭРХ

**Б**ЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН Эрүүл мэндийн хөтөлбөр нь хүн бүрийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг бүрэн хангахад дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ нь хүний эрхийг хангах чухал бүрэлдэхүүн хэсэг юм. НҮБ-ын Хүн амын сан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх мэдээлэл, чанартай үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй болгоход чиглэсэн аливаа бодлого, стратеги, төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлдэг. Ялангуяа охид, эмэгтэйчүүд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ, эрхийг хангах нь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүлэх чиглэлийн цөм юм.

### **Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг цогцоор нь хуульчлахад санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг үзүүлэв**

2016 онд НҮБ-ын Хүн амын сан Эх хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийг эцэслэхэд нь УИХ-ын ажлын хэсэгт техник арга зүйн дэмжлэг үзүүлэв. Уг хууль батлагдсанаар Монголд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах үйлчилгээ эмэгтэйчүүд, залуучуудад хүртээмжтэй болох юм.

Азийн хөгжлийн банктай хамтран НҮБ-ын Хүн амын сан Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын концепцийг боловсруулахад дэмжлэг үзүүлэв. УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол,



соёл, шинжлэх ухааны байнгын хороотой хамтын ажиллагаагаа өргөжүүлж, НҮБ-ын Хүн амын сан Залуучуудын хөгжлийн тухай хуулийн төслийн талаарх УИХ-ын хэлэлцүүлгүүдэд дэмжлэг үзүүлээ. Хэлэлцүүлгээр залуучуудын эрүүл мэнд, тухайлбал бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, тэдний дунд улам тархаж буй бэлгийн замаар дамжих халдвар, нийгмийн салбар дахь инновац, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэлэлцэж, тогтвортой хөгжлийн зорилт болон Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар баталсан үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг сурталчлав. НҮБ-ын Хүн амын сан мөн анхан шатны тоон мэдээ, мэдээллийг тайлагнах маягыг шинэчилж, Эрүүл мэндийн үндэсний мэдээллийн системд тогтвортой хөгжлийн зорилтуудын эрүүл мэндийн мэндийн шалгуур үзүүлэлтүүдийг тусгахад Эрүүл мэндийн яаманд дэмжлэг үзүүлээ.

## **Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогыг боловсруулахад хамтран ажиллав**

Охид, эмэгтэйчүүд, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ, эрхийг хангахад чиглэсэн үндэсний бодлогыг боловсруулахад НҮБ-ын Хүн амын сан Монгол Улсын Засгийн газартай идэвхитэй хамтран ажиллалаа. НҮБ-ын Хүн амын сангийн санхүү, техник арга зүйн дэмжлэгтэйгээр Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний 4 дэх хөтөлбөрийн (2012-2016) хэрэгжилтийг үнэлэв. Үнэлгээнээс үзвэл Монгол улсад эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн зорилтод хүрэхэд НҮБ-ын Хүн амын сангийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах хөтөлбөр ихээхэн хувь нэмэр оруулж, улмаар Монгол улс эхийн эндэгдлийг бууруулах зорилтдоо хүрсэн дэлхийн 9-хөн орны нэг болжээ.

НҮБ-ын Хүн амын сангаас баримтад тулгуурлаж бодлого боловсруулах явдлыг дэмжиж ухуулга нөлөөлөл, техник арга зүй, санхүүгийн тусламж үзүүлсэнээр бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, түүний дотор эхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дэд бүтцийг сайжруулахад хуваарилах улсын төсөв нэмэгдэж, жирэмсний үеийн хяналтанд хамрагдах явдал (95%) өсч, эхийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид чадавхижиж, оношилгоо, эмчилгээний шинэ аргууд нэвтэрсэн байна. Үүнд тулгуурлан Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний шинэ хөтөлбөрийг боловсруулж, 2017 оны эхээр засгийн газраар батлуулахаар бэлтгээд байна.

2016 онд НҮБ-ын Хүн амын сан гэр бүл төлөвлөлтийн талаар хэд хэдэн судалгаа түүний дотор *жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмж, гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ, гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа* хийхэд дэмжлэг үзүүлэв. НҮБ-ын Хүн амын сангийн эдгээр судалгаанд үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгч, эрүүл мэндийн тогтолцооны шийдвэр гаргагчдыг хамруулан гэр бүл төлөвлөлтийн талаарх цогц дүр зургийг тодорхойлсон нь шинээр томилогдсон төрийн албан хаагчдад нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар ухуулж ойлгуулахад тус дөхөм болж байна.

## **Телемедицин төслийн үйл ажиллагаа**

Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй Телемедицин төслийн хүрээнд ихээхэн шинэлэг арга, техникийг нэвтрүүлж, хөдөө орон нутгийн амаржих газар, эмнэлгүүдийг нийслэл дэх гурав дахь шатлалын эмнэлэгтэй цахим хэлбэрээр холбож, эмч мэргэжилтэн, эмнэлгүүдийг холбосон сүлжээ байгуулав. Ингэснээр Монголын хамгийн алслагдсан нутагт амьдарч буй жирэмсэн эмэгтэй хөрөнгө мөнгө, хүч чадлаа шавхан Улаанбаатарт ирэлгүйгээр гурав дахь шатлалын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нутагтаа авдаг болсон юм. Төслийн хүрээнд цахим сүлжээгээр дамжуулан алсын зайнаас зөвлөгөө өгөх замаар аймгийн түвшинд жирэмсний хүндрэлийг эрт илрүүлэн, цаг алдалгүй

эмчилж, эх, нярайн хүндрэл тохиолдлуудыг эмнэлгүүд өөр хоорондоо тогтмол зөвлөж, эх хүүхдийн эрүүл мэндийн тандалтын тогтолцоог бүрэн ашиглаж, ур чадварт суурилсан эх барихын яаралтай тусламжийг нэвтрүүлж, мэс заслын чадвар сайжруулах сургалтуудыг ажлын байран дээр явуулж, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд цахим кредит систем бүхий 5 модультай цахим сургалтын суурийг тавьж, сайжруулан тус улсад эхийн эндэгдлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулав.

Төслийн эцэст Монголд эх барихын яаралтай тусламж үзүүлдэг эх барих, эмэгтэйчүүдийн нийт эмч нарын 70 % нь Телемедицин төслийн хүрээнд сургалтанд хамрагдсан байна. Төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, цаашид Засгийн газар бүрэн бие даан хэрэгжүүлдэг болгохын тулд Телемедицин төслийн хоёр шатлал (2007-2011 он болон 2012-2016 он)-ын хэрэгжилтийн талаарх мэдлэг, туршлагыг өвлүүлэх арга хэмжээг 2016 оны 12-р сард зохион байгуулав.

2016 оны 7-р сард Люксембургийн Ерөнхий сайд Ксавье Беттел Монголд Ази Европын уулзалтад оролцоходоо Телемедицин төсөл хэрэгжиж буй эмнэлгүүдэд зочлов. Улмаар Телемедицин төслийн хугацааг сунгаж, эцсийн шатлалыг 2017-2019 онд хэрэгжүүлэхээр боллоо.

### **Эх, нярайн эрүүл мэндийг цаашид сайжруулахыг зорьж байна**

2016 онд эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлт тутамд 26 байснаа 348 болж өсөхөд НҮБ-ын Хүн амын сан шуурхай хариу арга хэмжээ авч, эхний үнэлгээгээр үйлчилгээ үзүүлж буй цэгүүдэд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм хэрэгсэл тасалдсаныг олж тогтоов. Энэ нь жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн хангагдаагүй хэрэгцээ, хүсээгүй жирэмслэлт ихссэнийг илтгэж байв. НҮБ-ын Хүн амын сан нэн даруй богино хугацааны арга хэмжээ авч, жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэлийн яаралтай худалдан авалт хийж, дунд хугацаанд уг эм хэрэгсэлд зориулж улсаас тогтмол төсөв хуваарилуулахын тулд үндэсний эрх баригчид болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай дээд түвшинд хэлэлцээ хийв. НҮБ-ын Хүн амын сангийн хууулга нөлөөллөөр ЭМЯ улсын төсвөөс хуваарилсан 52,561 ам.доллараар жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн яаралтай худалдан авалт хийж 8 сарын хэрэгцээг хангав. НҮБ-ын Хүн амын сан мөн эмч ажилтнууд ялангуяа шинээр сургууль төгссөн эмч нарт зориулж эх барихын яаралтай тусламжийн практик сургалтыг зохион байгуулав. Энэ нь Монгол улсын Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Анагаах ухааны тэнхимд эх барих, нярайн

*Люксембургийн  
Ерөнхий сайд  
Ксавье Беттел  
Монголд Эх,  
хүүхдийн эрүүл  
мэндийн үндэсний  
төвд зочлов.*



сургалтын хөтөлбөрийг өөрчлөхөд үзүүлж буй НҮБ-ын Хүн амын сангийн тусламжийн нэг хэсэг юм. Ур чадварт тулгуурласан 'SCORPIO' сургалтын аргыг клиникийн хэд хэдэн хэсэгт өргөжүүлэн нэвтрүүлэв.

Үүнээс гадна НҮБ-ын Хүн амын сан эх, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд ЭХЭМҮТ, бүс болон аймгийн амаржих газруудад 500,000 ам.долларын үнэ бүхий тоног төхөөрөмж худалдан авч, хүлээлгэн өгөв.

Олон улсын эх баригчдын холбооноос боловсруулсан стандартад тулгуурлан эх баригч нарын ажлын байрны тодорхойлолт, дадлага, сургалтын хөтөлбөрийг өөрчлөхөд НҮБ-ын Хүн амын сан 2016 онд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлээ. Santé Sud хэмээх Францын төрийн бус байгууллагатай хамтран НҮБ-ын Хүн амын сан Монголын эх баригч нартай холбоотой эмчилгээ, эрх зүйн хүрээ, ажлын байрны тодорхойлолт, сургалтын хөтөлбөрийг хянаж шинэчлэхэд дэмжлэг үзүүлэв. Энэ хамтын ажиллагаа нь Монголд эх баригч нарыг дан ганц эх нярайн тусламж үзүүлээд зогсохгүй олон нийтэд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх чадвартай болгох замаар эх барихын тусламж үйлчилгээг шинэчлэх зорилготой.

### **Хилийн дагуух бүс нутагт БЗДХ-аас урьдчилан сэргийлэх төслийг БНХАУ-тай хамтран хэрэгжүүлж дууслаа**

Люксембургийн Засгийн газраас санхүүжүүлсэн “Хилийн дагуух бүс нутагт БЗДХ-аас урьдчилан сэргийлэх төсөл” 2016 онд хэрэгжиж дууслаа. 2010-2015 онд хэрэгжүүлсэн ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратегийн зорилтын хүрээнд урьдчилан сэргийлэх чанартай үзлэг, үйлчилгээг өргөжүүлсэнээр хамгийн эрсдэл ихтэй хүн амын дунд ХДХВ/БЗДХ-т өртөх эрсдэл ихээхэн буурсан нь төслийн үнэлгээгээр тогтоогдсон байна. Энэ төсөл нь мөн залуучууд, өсвөр үе, эрсдэлт хүн амын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ, эрхийг хангахад голчлон анхаарав. Төслийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд онцгой түншлэлийн харилцаа тогтоож, Монгол болон Хятад дахь НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газруудад хамтарсан удирдах зөвлөлийг байгуулж, уг төслийг стратеги удирдлагаар хангаж ажиллав.

Төслийн хүрээнд эмэгтэй биеэ үнэлэгчид, хөдөлгөөнт хүн амд зориулж зан үйлийг өөрчлөх цуврал үйл ажиллагаа хэрэгжүүлж, олон нийтэд тулгуурласан сургалт, зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээ үйлчилгээ үзүүлэв. Төслийн эцсийн үнэлгээнээс үзвэл олон нийтэд тулгуурласан бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, БЗДХ/ХДХВ-ийн шинжилгээ эмчилгээнд хамрагдсан эмэгтэй биеэ үнэлэгчдийн тоо 2014 онд 180 байснаа 2016 онд 1200 болж өсчээ. Төсөл хэрэгжүүлсэн 5 жилийн хугацаанд эмэгтэй биеэ үнэлэгчдийн дунд шинээр тэмбүүгийн халдвар авсан тохиолдол гурав дахин буурч, ХДХВ/ДОХ-ын талаар зөв цогц мэдлэгтэй эмэгтэй биеэ үнэлэгчдийн хувь 2012 онд 28.8% байснаа 2016 онд 39.7% болж, хөдөлгөөнт хүн амын дунд энэ тоо 17.2% байснаа 22.9% болж өссөн байна. Эмэгтэй биеэ үнэлэгчдийн ихэнх (87.5%) нь сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн шинжилгээнд хамрагдсан нь 2012 онд 74% байсан үзүүлэлтээс өссөн байна.



### III. ЖЕНДЭР

**Ж**ендэрийн хөтөлбөр нь жендэрийн үндэсний тогтолцоог бэхжүүлж, тус улсад Тогтвортой хөгжлийн 5 дахь зорилтод заасан (жендэрийн тэгш байдлыг хангаж, бүх охид, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх) жендэрийн тэгш байдлыг ханган, ялангуяа холбогдох хуулийг боловсруулах, хүчирхийлэлд өртөгсдөд цогц үйлчилгээ үзүүлж, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх замаар жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх зорилготой. НҮБ-ын Хүн амын сан жендэрийн тэгш байдлыг хангаж, жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох хууль, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд тусалж, ухуулга нөлөөлөл хийхдээ иргэний нийгмийн түншлэл, олон нийтийн оролцоог дэмждэг.


#### Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах үйл явц

Хэдэн арван жилийн турш НҮБ-ын Хүн амын сан жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, үр дүнтэй хариу арга хэмжээ авах явдлыг дэмжиж ирэв. НҮБ-ын Хүн амын сангийн энэхүү дэмжлэг, оролцооны нэг гол үр дүн бол 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан явдал юм. Уг хууль 2016 оны 5-р сард батлагдсан боловч 9-р сард буцаагдаж, мөн оны 12-р сард өөрчлөлт хийгдэн, эцэслэн батлагдав. Энэ сацуу хүчирхийллийн эсрэг хамгааллыг сайжруулах элементүүд бусад хууль түүний дотор хууль сахиулах тухай хууль, цагдаагийн албаны тухай хууль, эрүүгийн хууль, зөрчлийн тухай хуулинд тусгагдав. Үйл явц сунжирсан хэдий ч НҮБ-ын Хүн амын сан үндэсний зөвлөлгөөнүүдийг зохион байгуулахад техник арга зүй, санхүүгийн дэмжлэгээ тасралтгүй үзүүлж, гол бодлого, шийдвэр



гаргагчдад чиглэсэн ухуулга нөлөөлөл хийв. Мөн олон нийт ч бас гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хугацаа алдалгүй УИХ-аар батлуулахыг тууштай дэмжиж байв. Энэ нь нийгэмд шийдвэрлэх шаардлагатай ноцтой асуудлуудын нэг нь жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл болохыг гэрчилж, бас НҮБ-ын Хүн амын сангийн ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа ихээхэн үр дүнтэй болсоныг илтгэж байв. УИХ-ын эмэгтэй гишүүд, УИХ дахь эмэгтэй гишүүдийн бүлэг, жендэр, хүний эрхийн элч УИХ-ын гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлага, иргэний нийгмийн гол байгууллагууд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулахад чухал үүрэг гүйцэтгэв.

## **Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх шинэ төслийг Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж эхлэв**



“Монголд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг санхүүжүүлж, хамтран ажиллах гэрээг Швейцарийн хөгжлийн агентлаг 2016 оны 6-р сард НҮБ-ын Хүн амын сантай байгуулав. Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Хууль зүй, дотоод хэргийн яам оролцон 2016 оны 9-р сард уг шинэ төслийг амжилттай хэрэгжүүлж эхэллээ. Төслийн хүрээнд Монголд анх удаа жендэрт суурилсан хүчирхийллийг цогцоор нь хэд хэдэн салбарыг хамруулан шийдвэрлэхийг зорих бөгөөд ингэхдээ жендэрт суурилсан хүчирхийллийн талаар тоон мэдээ, мэдээлэл цуглуулж, судалгаа хийн, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, ухуулга нөлөөлөл хийн, хүчирхийлэлд өртөгсдөд шаардлагатай үйлчилгээг цогцоор нь үзүүлэхийг зорино. Холбогдох яамд, иргэний нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, төслийг хэрэгжүүлэн, жендэрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

Статистикийн үндэсний хороо Монголд анх удаа жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтыг судална. Ингэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглаж, судалгааг хийх бөгөөд

судалгаа бүх аймгийг хамарна. Төслийн хүрээнд нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг цогц үйлчилгээ үзүүлдэг болгож, мөн өнгөрсөн жилүүдэд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан нэг цэгийн үйлчилгээний 6 төвийг сайжруулна. Нэг цэгийн үйлчилгээий төвүүд нь эрүүл мэндийн тусламж, сэтгэл зүйн зөвлөгөө, цагдаагийн хамгаалал, хууль эрх зүйн үйлчилгээ, нийгмийн тусламж бүхий цогц үйлчилгээг хүчирхийлэлд өртөгсдөд нэг цэгээс үзүүлэх бөгөөд ингэснээр хүчирхийлэлд өртөгч нь энэ бүх үйлчилгээг авах гэж тал тал тийш явах шаардлагагүй болох юм. Мөн төв бүрт үзүүлж буй төрийн үйлчилгээг зохицуулах орон нутгийн салбар дундын багийг байгуулна.

### **Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хууль боловсруулах нөхцөлийг бүрдүүлэв**

НҮБ-ын Хүн амын сан жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах (шалгуур үзүүлэлт, санамж жагсаалт бүхий) удирдамжийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Багануур дүүргийн засаг даргын тамгын газарт нэвтрүүлэв. Мөн төрийн албан хаагчдад зориулсан төгсөлтийн дараах сургалт явуулдаг Удирдлагын академийн сургалтын хөтөлбөрт жендэрт суурилсан төсөв боловсруулах тухай 24 цагийн сургалтын багцыг боловсруулж, тусгав. Сургалтын багцад цахим сургалтын хөтөлбөр, сэдэв тус бүрийн тухай илтгэлүүд, жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах тухай видео хичээлүүд, дэлгэрэнгүй мэдээлэл авах вэб хуудасны линкүүд, өөрийгөө үнэлэх хэрэгсэл, бие даан суралцах материалуудыг орууллаа. Сангийн яамны 25 ажилтан, бусад яам, дүүргийн жендэрийн асуудал хариуцсан 25 ажилтан 2016 онд цахим сургалтад хамрагдав.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг (2013-2016) үнэлэхэд НҮБ-ын Хүн амын сангаас санхүү, техник арга зүйн дэмжлэг үзүүлж, үнэлгээний дүнг үндэсний семинараар хэлэлцэж, Засгийн газраар батлуулахаар өргөн барив. Мөн Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөрийг (2017-2021) боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, үндэсний болон бүс нутгийн түвшинд яам, агентлагуудыг оролцуулсан зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүллээ.

Жендэрийн талаарх салбарын дэд хөтөлбөрүүдийг боловсруулах удирдамжийг батлуулахаар Засгийн газарт өргөн бариад байгаа бөгөөд ЭМЯ, Сангийн яам уг удирдамжийг ашиглаж байна. Мөн 2016 онд гурван аймагт (Баянхонгор, Говь-Алтай, Завхан) жендэрийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулж батлав.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн (ЭЯГБХУТК) хэрэгжилтийн талаарх үндэсний 8 болон 9 дэх ээлжит илтгэлийг бэлтгэхэд НҮБ-ын Хүн амын сан тусалж, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, Женевт тайланг танилцуулахад дэмжлэг үзүүлэв. ЭЯГБХУТК-ийн хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хэсэг Жендэрийн үндэсний хорооны дэргэд байгуулагдав.

### **Гамшгийн үед ариун цэвэр, эрүүл ахуйн багц түгээв**

Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын нэгдсэн сангаас нийт 473,131 ам.доллар дайчилж, 2016 онд зуданд өртсөн малчдад тусламж үзүүлэв. Уг тусламжийн хүрээнд НҮБ-ын хүн амын сан гамшигт өртсөн охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээг хангахын тулд 6 аймгийн 69 сумын эмнэлэгт тусламж үзүүлж, 1,333 эмэгтэй (943 жирэмсэн эмэгтэй, 390 амаржсан эхчүүд)-д хүрч үйлчлэн, цаг агаарын хүнд нөхцөлд тэдэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэв. Мөн өдөр тутмын ариун цэвэр, эрүүл ахуйн хэрэгсэлээс бүрдсэн багцыг Монгол улсын сонгосон 6 аймгийн 4390 зорилтот өрхийн 7,962 эмэгтэйд түгээв. НҮБ-ын Хүн амын сан Онцгой байдлын ерөнхий газартай хамтран (ОБЕГ) гамшгийн үед цаг алдалгүй хариу арга хэмжээ авч, охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээг



*Хувцас, ариун  
цэврийн хэрэгсэл,  
эрүүл ахуйн эд  
зүйлсээс бүрдсэн  
Ариун цэвэр, эрүүл  
ахуйн багцыг  
НҮБ-ын Хүн  
амын сан зуданд  
өртсөн малчин  
эмэгтэйчүүдэд  
түгээж, гамшгийн  
үед тэднийг нэр  
төрөө хамгаалж,  
эрүүл ахуйгаа  
хангахад нь туслав.*



хангахад ихээхэн анхаарав. Онцгой байдлын үед улс үндэстний зүгээс тусламж үзүүлэхдээ охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээг орхигдуулахгүй байх зорилгоор олон нийт, сургууль, боловсролын байгууллагуудад байгалийн гамшгийн бэлэн байдлыг хангах үндэсний сургалт, уулзалтыг зохион байгуулахад НҮБ-ын Хүн амын сан Шадар сайдын ажлын албанд дэмжлэг үзүүлэв.

## IV. ЗАЛУУЧУУД

**З**алуучуудын хөгжлийн хөтөлбөр нь залуучуудыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхээ эдэлж, амьдрах ухааны чанартай сургалтанд хамрагдаж, хувь хүн болон өсч хөгжих замаар нөөц бололцоогоо бүрэн ашиглах боломжоор хангахыг зорьдог. НҮБ-ын Хүн амын сан залуучуудын талаарх үндэсний бодлого боловсруулах, амьдрах ухааны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, залуучуудыг эрх мэдэлжүүлж, сургуулийн орчинд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг ялангуяа тэр бүр үйлчилгээ авч чаддаггүй эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлж Засгийн газар, төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.

### Залуучуудын цогц бодлого боловсруулахыг зорьж байна

2016 онд НҮБ-ын Хүн амын сан, хөтөлбөр хэрэгжүүлэгч түнш байгууллага, залуучуудын ухуулга нөлөөллийн хүчин чармайлтын үр дүнд Монгол улсад залуучуудын хөгжлийн тогтолцоо, салбарын суурийг тавьж, залуучуудын агентлагийг байгуулах түүхэн шийдвэрийг Засгийн газар гаргав.

Залуучуудын асуудал хариуцсан анхны төрийн байгууллага болох Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяанд байгуулагдав. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь залуучуудын хөгжилтэй холбоотой засгийн газрын тодорхой үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй бөгөөд залуучуудын талаарх эрх зүй, бодлогын орчинг сайжруулж, залуучуудын хөгжлийн сан байгуулж, салбар хоорондын зохицуулалтыг





хангаж, залуучуудын ажилтнуудыг бэлтгэж, залуучуудын хөгжлийн мэдээлэл, менежментийн системийг бий болгож, залуучууд судлалыг дэмжихээр төлөвлөж байна.

Шинэ Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт НҮБ-ын Хүн амын сангаас дэмжиж буй гол асуудлууд тухайлбал амьдрах ухааны боловсрол, эрүүл мэндийн боловсрол (нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг онцолсон), сургуулийн орчинд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, болон залуучуудын хөгжлийн хууль, үндэсний хөтөлбөр тусгагдсан байна.

Ялангуяа өөрсдөд нь нөлөөлөх бодлого, шийдвэрүүдийг боловсруулахад залуучуудын үр дүнтэй оролцоог дэмжих нь залуучуудын хөгжлийн талаар үр өгөөжтэй бодлого боловсруулахад чухал юм. Залуучуудын удирдаж буй иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхижуулж, хүний эрхийн зарчимд гүнзгий тулгуурласан залуучуудын үр өгөөжтэй оролцоог хангах жишгийг бий болгохуйц залуучуудын удирдсан ухуулга, нөлөөллийн санаачлагуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын Хүн амын сан Иргэний боловсролын төвтэй хамтран ажиллаж байна. Ялангуяа НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр залуучуудын манлайлал бүхий ухуулга нөлөөлөл, хяналт, шинжилгээ үнэлгээний удирдамжийг Залуучуудын хөгжлийн төвүүд, залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд, залуучуудад үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан боловсруулав. Үүний дараа уг удирдамжийг хэрэгжүүлэх сургалтуудыг зохион байгуулж, техник арга зүйн чиглэл, дэмжлэгээр хангахын сацуу залуучуудын манлайлал бүхий санаачлагуудад бага хэмжээний тэтгэлэг олгож, дэмжив. Мөн шийдвэр гаргах үйл явц дахь залуучуудын оролцоог дэмжих, залуучуудад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бодлого, эрх зүйн хүрээг сайжруулахад чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээнүүдийг холбогдох олон улсын өдрүүдэд зохион байгуулав. Энэ арга хэмжээнүүдийн хүрээнд 2016 онд 101,550 залуучууд, иргэдэд хүрч үйлчилсэн нь 2015 оныхоос гурав дахин их байна.

2016 оны дундуур болсон УИХ-ын сонгуулийн өмнө Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам Залуучуудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогыг эцэслэсэн юм. Сонгуулийн дараа бүтэц нь шинэчлэгдсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам залуучуудын эрх, үүрэг хариуцлага, засгийн

газрын агентлагуудын үүрэг хариуцлага, залуучуудын хөгжлийн санхүүжилт, зохицуулалт, дэмжлэгийн гол механизмуудыг тодорхой заасан залуучуудын хөгжлийн тухай хуулийг боловсруулж, батлуулахад ихээхэн ахиц гаргав. Мөн орон нутгийн эрх баригчдын дунд залуучуудын хөгжилд хувь нэмэр оруулж, тууштай дэмжих явдал нэмэгдсэн нь санхүүжилт бүхий залуучуудын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, баталсаны илрэл юм. Ялангуяа Завхан, Өмнөговь, Орхон аймаг, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт нийт 115 сая төгрөгийн санхүүжилттэй залуучуудын дэд хөтөлбөрүүд батлагдсан байна. 2016 онд залуучуудын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, залуучуудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг боловсруулж залуучуудын хөгжлийг цогцоор нь авч үзсэн нь Монгол улсад анх удаа залуучуудын хөгжлийн дэмжлэгт орчинг бүрдүүлэхэд ихээхэн ахиц болов.

Тоон мэдээ мэдээлэл, баримтаар баталгаажуулан тогтвортой хөгжлийн зорилт болон залуучуудын зорилтуудын уялдааг тайлбарласан ухуулга нөлөөллийн сурталчилгаа нь үр дүнтэй болж, үндэсний болон орон нутгийн түвшинд шинээр томилогдсон засаг, захиргааны албан тушаалтнууд энэ асуудлыг тууштай дэмждэг болов.

### **Монголын залуучуудыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээгээр хангаж байна**

ЭМЯ-тай хамтран НҮБ-ын Хүн амын сан 2016 онд Өмнөговь аймгийн Ханбогд, Замын үүд суманд өсвөр үе, залуучуудад ээлтэй хоёр клиник байгуулав. Ингэснээр өсвөр үе, залуучуудад ээлтэй нийт 21 клиникийг НҮБ-ын Хүн амын сан түншүүдийнхээ хамт сонгосон 11 аймаг, Улаанбаатар хотын 4 дүүрэгт байгуулаад байна. Эдгээр клиникүүд өсвөр үе, залуучуудад БЗДХ-ын үйлчилгээ, зөвлөгөө өгч, эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэж, шаардлагатай үйлчлүүлэгчдийг мэргэжлийн эмнэлгүүдэд шилжүүлж, үе тэнгийн сургалт зохион байгуулж байна.

ЭХЭМҮТ-д үзүүлж буй өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний талаарх тогтсон мэдээллийн системийг НҮБ-ын Хүн амын сангаас дэмжиж ажилладаг бөгөөд уг мэдээллийн системээс авсан тоон мэдээ, мэдээллээс үзвэл 2016 онд нийт 32,143 залуучууд өсвөр үе, залуучуудад ээлтэй клиникээр үйлчлүүлсэн байна. Энэ нь жилд 24,000 залуучуудад үйлчлэх зорилтыг ихээхэн давуулан биелүүлсэн үзүүлэлт юм. Залуучуудын хөгжлийн төвөөс өсвөр үе, залуучуудад ээлтэй клиникүүдэд шилжүүлэх үйлчилгээнд 545 залуус хамрагджээ.

Мөн өсвөр насны охид хөвгүүдийн ерөнхий биеийн хөгжил, өвчин эмгэгийг оношилж, эмчлэх, зөвлөгөө өгөх ур чадвар, өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх удирдамжийн хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолт, дэмжиж, удирдах чадвар, НҮЭМ-ийн эм хэрэгсэлийн хангалтыг хянах CHANNEL програм хангамжийг ашиглах тухай нэлээд олон сургалтыг зохион байгуулахад ЭХЭМҮТ болон ЭМЯ-нд дэмжлэг үзүүлэв. Эдгээр сургалтад өсвөр залуучуудад ээлтэй клиникүүдийн эмч, зөвлөгч нар болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн зохицуулагчид, аймаг дүүргийн эмнэлгүүдийн хангалтын менежерүүд зэрэг нийт 150 үйлчилгээ үзүүлэгчид оролцсон байна.

Тайлант хугацаанд цуврал сургалт, аянуудыг зохион байгуулах замаар үе тэнгийн сургагч нарын сүлжээг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр бэхжүүлэв. Үе тэнгийн сургагч нарыг бэлтгэх сургалтыг 8 аймаг (Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Баянхонгор, Дорнод, Өмнөговь аймгийн Ханбогд сум), Улаанбаатар хотын 1 дүүрэг (Баянзүрх)-т зохион байгуулав. Сургагч нарыг бэлтгэх сургалт болон үе тэнгийн Ү-Реег сүлжээний сургагч багш нарын үйл ажиллагааны үр дүнд 305 залуус үе тэнгийн сургагч нарыг бэлтгэдэг багш болж, 50 залуус үе тэнгийн сургагч болсон байна. Уг сүлжээ улам өргөжиж, 2016 онд нийт 15,520 залуучуудад хүрч, гэр бүл төлөвлөлт, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай мэдээлэл түгээсэн байна.



Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх түүний дотор БЗДХ болон жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлаар залуучуудад чиглэсэн зан үйлийг системтэйгээр өөрчлөх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд нь Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнд дэмжлэг үзүүлэв. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн зан үйлийг өөрчлөх харилцааны сургалтын модулуудыг боловсруулж, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, үйлчилгээ үзүүлэгчид, сургуулийн багш, эмч, нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулж, гэр бүл төлөвлөлт, НҮЭМ, БЗДХ, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай эерэг мэдээлэл бүхий зан үйлийг өөрчлөх харилцааны төрөл бүрийн материалуудыг залуучуудад зориулан боловсруулж, туршин, түгээв.

Төслийн дунд хугацааны үнэлгээг хийж, залуучууд, төслийн үйл ажиллагаа, үр нөлөөний талаар чанарын болон тоон мэдээ, мэдээллүүдийг цуглуулав. Судалгаанаас үзвэл 15-34 насны залуучуудын 34.2% нь ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх арга замыг зөв тодорхойлсон байна. Энэ нь суурь судалгааны үед 22% (2012) байснаа, 2016 оны зорилтыг давж, 12.2%-иар өсчээ.

## Амьдрах ухааны боловсрол

2016 онд НҮБ-ын Хүн амын сан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон түүний харъяа агентлагууд болох Насан туршийн боловсролын үндэсний төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын их сургуультай нягт хамтран ажиллах замаар амьдрах ухааны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, залуучуудад амьдрах ухааны боловсрол олгох хүний нөөцийн чадавхийг сайжруулахад хувь нэмэр оруулав. Туршилтын зорилгоор урьд нь байгуулсан амьдрах ухааны 32 танхим (ерөнхий боловсролын 5 сургууль, насан туршийн боловсролын 11 төв, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн 12 төв, багш бэлтгэх 4 хүрээлэн)-ын үйл ажиллагааг үргэлжлүүлэв. Тайлант хугацаанд амьдрах ухааны танхимуудын зохион байгуулсан үйл ажиллагаа, сургалтад 20,612 залуучууд оролцсон байна. Насан туршийн боловсролын бүс нутгийн арга зүйн төв болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн багш, арга зүйч нар сургагч бэлтгэх сургалтад хамрагдсан нь амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг хянаж, арга зүйн удирдлагаар хангах чадавхийг сайжруулав. Амьдрах ухааны чиглүүлэгч нарын гарын авлагыг дахин хэвлэж, улс орон даяар түгээж, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудад зориулсан амьдрах ухааны боловсролын гарын авлагыг эцэслэн, хэвлүүлж, улс орон даяар тусгай сургуулиуд болон залуучуудын хөгжлийн төвүүдэд түгээв.

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан залуучуудын хөгжлийн 16 төв залуучууд түүний дотор боловсролын үйлчилгээ авах боломжгүй эмзэг бүлгийн залуучуудад амьдрах ухааны боловсролын сургалт зохион байгуулав. Тайлант хугацаанд 6,324 залуус Залуучуудын хөгжлийн төвүүдэд амьдрах ухааны сургалтанд оролцсон байна. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээнээс үзвэл залуучууд амьдрах ухааны боловсролд ихээхэн сэтгэл хангалуун буюу 10 залуу тутмын бараг 9 нь амьдрах ухааны боловсролын хөтөлбөрт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлжээ.


НҮБ-ын Хүн амын сан 2016 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон түүний аймаг, дүүрэг дэх салбаруудад чиглэсэн ухуулга нөлөөллийн үйл ажиллагаагаараа дамжуулан Залуучуудын хөгжлийн төвүүдийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмэр оруулав. НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн 16 төв Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлага дор ажилаж, 15-34 насны залуучууд ялангуяа эмзэг бүлгийн залуучуудад дэмжлэгт үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэв. Залуучуудын хөгжлийн төвүүд амьдрах ухааны боловсрол, дэмжлэгт бүлэг, сонирхолоор нэгдсэн клубын үйл ажиллагаануудаар дамжуулан залуучуудын хөгжлийг дэмжиж, чөлөөт цагаа үр ашигтай өнгөрөөх боломжийг бүрдүүлж, залуучуудын манлайлсан санаачилгуудыг хэрэгжүүлж, залуучуудыг шийдвэр гаргах үйл явцад оролцоход тусалж байна. Дэмжлэгт бүлгүүдийг

чиглүүлж, хөгжүүлэх, давуу талд тулгуурлан олон нийтийг дайчлах арга, нэгдсэн зорилготой болох, залуучуудын хөгжлийн үйл ажиллагаануудын үр дүнд суурилсан төлөвлөлт, тайлагналт зэрэг сэдвүүдээр залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудад зориулж 5 хоногийн чадавхижуулах сургалтыг зохион байгуулав.

2016 онд НҮБ-ын Хүн амын сангаас дэмжсэн залуучуудын хөгжлийн бүх үйл ажиллагаа нь жендэрийн мэдрэмжтэй, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон жендэрийн асуудлуудыг тусгасан байсан юм. Тухайлбал, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төв, багш нарыг бэлтгэх их сургуулиуд, болон залуучуудын хөгжлийн төвүүдэд нэвтрүүлсэн амьдрах ухааны боловсролын хөтөлбөр нь жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх модултай төдийгүй бусад бүх модулд жендэрийн тэгш байдалтай холбоотой ойлголт, зарчмуудыг тусгав. Эрчүүд бол нийгмийг өөрчлөх гол элемент гэдэг ойлголтод тулгуурлан, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх SASA! аргачлалын талаарх хоёр дахь шатлалын сургалтад залуучуудын хөгжлийн төвийн бүх ажилтнууд хамрагдав. Ухуулга нөлөөлөл, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх сурталчилгаа мэдээллүүдэд жендэрийн тэгш байдлыг тусгаж байв. Завхан, Өмнөговь, Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт сонгосон 4 сургуульд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Аюулгүй сургууль” санаачилгыг туршилтаар хэрэгжүүлж, хүчирхийллийн талаарх мэдлэгийг сайжруулах үйл ажиллагаанд нийт 4,768 багш, сурагч, эцэг эхчүүд хамрагдав. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаар (аян, арга хэмжээ, чуулган) дамжуулан хүрч ажилласан залуучуудын тоо 2015 онд 38,454 байснаа 2016 онд 158,279 болж 4 дахин өсөв. Төслийн зорилтот бүс нутагт (Баян-Өлгий, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Завхан, Чингэлтэй дүүрэг) сонгосон ерөнхий боловсролын 4 сургуульд “Аюулгүй сургууль” санаачлагын үр дүнг үнэлэв.


Төслийн дунд хугацааны үнэлгээнээс үзвэл жендэрт суурилсан хүчирхийллийн тухай зөв мэдлэгтэй залуучуудын хувь суурь үнэлгээний үед 37.5% байснаа 9,2%-иар өссөн байна. Судалгаанаас үзвэл жендэрт суурилсан хүчирхийллийг зөв тодорхойлж буй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 6%-иар их байна. Насны бүлгүүд дотроос жендэрт суурилсан хүчирхийллийг зөв тодорхойлсон 15-16 насныхан бусад бүлгүүдээс 10%-иар их байлаа.

*Шинэчлэн, боловсронгуй болгосон “Амьдрах ухааны боловсрол”-ын чиглүүлэгч нарт зориулсан гарын авлагад тусгасан сэдвүүдээс цөөн хэдийг нь дурьдвал: Өөртөө итгэх итгэл, Харилцаа, Холбоо тогтоох, Бэлгийн амьдрал, БЗДХ/ХДХВ-ээс сэргийлэх, Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх.*




1

ӨӨРТӨӨ ИТГЭХ ИТГЭЛ




2

ХАРИЛЦАА




3

ХОЛБОО ТОГТООХ




10

БЭЛГИЙН АМЬДРАЛ, БЗДХ/ХДХВ-ЭЭС СЭРГИЙЛЭХ НЬ



9

ТУНГААН БОДОХ



11

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ

## V. ХҮН АМЫН ТООН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

**Х**үн амын бодитой үнэн зөв тоон мэдээ түүний дотор хүн амын динамик хөдөлгөөн, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх, жендэртэй холбоотой тоон мэдээ, мэдээллийг бодлого боловсруулахад ашигладаг болгох нь хүн ам ба хөгжлийн хөтөлбөрийн зорилго юм. НҮБ-ын Хүн амын сан нь үндэсний бодлогуудыг боловсруулж, хэрэгжүүлэх, тоон мэдээ, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийн, хүн амын тоон мэдээ, мэдээллийг засгийн газрын шийдвэр гаргах үйл явцад ашиглахад дэмжлэг үзүүлдэг.

### Хүн ам, хөгжлийн талаар хууль боловсруулахад дэмжлэг үзүүлэв

2016 онд НҮБ-ын Хүн амын сан Хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, эцэслэхэд санхүүгийн болон техник арга зүйн дэмжлэг үргэлжлүүлэн үзүүлэв. Уг бодлого 2016 оны 5-р сард Засгийн газраар батлагдсан бөгөөд салбарын бүх яамдад (тухайлбал, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, боловсрол) Тогтвортой хөгжлийн зорилт, Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар батлагдсан мөрийн хөтөлбөрийг дэмжих эрх зүйн хүрээг бүрдүүлэв. Гэр бүл төлөвлөлтийн мэдээлэл, үйлчилгээ авах хувь хүний эрхийг анх удаагаа тодорхой дурьдсан нь хосуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг баталгаажуулав. Хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг хянах хүрээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам боловсруулав.

### Өнөөгийн нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг шийдвэрлэхэд шаардлагатай тоон мэдээ, мэдээлэл цуглуулав

НҮБ-ын Хүн амын сан Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-той хамтран анх удаа хүн ам, орон сууцын завсарын тооллого хийж, Монголд тулгарч буй нийгэм, эдийн засгийн бэрхшээлтэй асуудлыг шийдэх төлөвлөгөө, төсөв, стратегийг боловсруулахад шаардлагатай тоон мэдээ, мэдээллийн томоохон эх үүсвэрийг бүрдүүлэв. Монгол улс тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, боловсруулах хамгийн зардал хэмнэсэн арга болох бүртгэлд тулгуурласан статистикийн аргыг анх удаагаа ашиглав. Энэ арга нь мэдээллийн баазад оруулсан мэдээллийг шууд хянах замаар цуглуулсан тоон мэдээ, мэдээллийн чанарын баталгааг хангадаг.

## VI. МЕНЕЖМЕНТИЙН ҮР ДҮН



### Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэв

Залуучуудын хөгжлийн төвүүдийн сонгосон залуучуудыг амжилттай ажиллаж буй залуу бизнес эрхлэгчдийн сургалтанд хамруулж, тэдний бизнесээ эхлүүлэх хүчин чармайлтыг дэмжих зорилгоор Junior Chamber International (JCI) Progress байгууллагатай Харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү санаачилгыг 2016 болон 2017 онд Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Дархан-Уул, Орхон аймгуудад 15-34 насны залуучуудад зориулж хэрэгжүүлэхээр болов.

Тус улсын хэвлэл мэдээллийн салбарт сэтгүүл зүйн мэргэжил, ур чадварыг сайжруулахын төлөө сэтгүүлчдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг гол байгууллага болох Монголын хэвлэлийн хүрээлэнтэй НҮБ-ын Хүн амын сан хамтран ажиллахаар болов. Хамтын ажиллагаа нь сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн





Улбар шар арга  
хэмжээнд сайн  
дураараа оролцсон  
уран бүтээлчид.



ажилтнуудыг жендэрт суурилсан хүчирхийллийн талаар зөв зохистой мэдээлэх чадавхитай болгох зорилготой. Хамтын ажиллагааны хүрээнд чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулж, хэвлэл мэдээллийнхний дунд уралдаан зарлаж, жендэрийн мэдрэмжтэй хяналт тавина.

Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг тэмцэлийг хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр улам өргөжүүлэх асар их нөөц боломж байгааг НҮБ-ын Хүн амын сан онцолж байна. Эмэгтэйчүүдийн хувцас, гоо сайхны бараа үйлдвэрлэж, худалдаалдагаараа нэртэй Монголын Гурван билэг ХХК 2016 онд НҮБ-ын Хүн амын сангаар дамжуулан гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд эмэгтэйчүүдийн хувцас, дотуур хувцас хандивлах хүсэлт тавьсан юм. НҮБ-ын Хүн амын сангаас дэмждэг нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байруудаар үйлчлүүлж буй гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тэдний хандивыг түгээхэд тус компанитай хамтран ажиллалаа.

“Orange Sessions” буюу “Улбар шар арга хэмжээ”-г 4 дэх жилдээ Монголын залуу уран бүтээлчидтэй хамтран зохион байгуулж, тэдний концерт тоглолтоор дамжуулан жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох уриалгыг түгээж байна. Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн “Улбар шар арга хэмжээ” нь Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох НҮБ-ын НЭГДЭЦГЭЭ аяныг дэмжиж эхлэлээ тавьсан бөгөөд энэ нь Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг дайчлах НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүлэх чиглэлд нийцэж байгаа юм. “Улбар шар арга хэмжээ”-нд сайн дураараа ая дуугаа өргөдөг уран бүтээлчид 2016 онд “Дэлхий ертөнцийг улбар шар болгоцгооё” дууг зохиосон нь том амжилт байлаа. Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоохын төлөө бид бүгд хамтдаа зүтгэх ёстой гэсэн уриалгыг түгээхээр тэдгээр авъяаслаг залуу уран бүтээлчид эрч хүчтэй дуу хөгжмийн дүрс бичлэг хийсэн юм. Дэлхий дахинаа өрнөдөг “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох 16 хоногийн аян”-ы үеэр уг дүрс бичлэгийг олон нийтэд амжилттай толилуулж, онлайнгаар цацаж, Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын төв болох Сүхбаатарын талбайн дэргэдэх том дэлгэцээр 7 хоног гаргаж, түгээв. Мөн НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын Ази, номхон далайн бүсээс зохион байгуулсан “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө НЭГДЭЦГЭЭ” дууны тэмцээнд Монголоос тэдний зохиосон дуу, дүрс бичлэгийг илгээж оролцов.

Өмнөговь аймгийн Ханбогд суманд Залуучуудын хөгжлийн төв, өсвөр үе, залуучуудад ээлтэй клиник, үе тэнгийн сургалтын сүлжээ байгуулж, залуучуудын хөгжлийн өөр бусад үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр 2015 онд Монголын хамгийн том уул уурхайн компани болох Оюу толгой ХХК НҮБ-ын

Хүн амын сантай төслийн гэрээг үзэглэсэн бөгөөд 2016 онд уг төсөлд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэв. Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан 1,600 залуус амьдрах ухааны сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээ, үе тэнгийнхний эерэг харилцаа сургалтад хамрагдсан байна. Мөн шинээр байгуулагдсан өсвөр үе, залуучуудад ээлтэй клиникээр 661 залуучууд үйлчлүүлжээ.

### Хөрөнгө, нөөц дайчлав

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 4,3 сая долларын төсөв бүхий төслийг эцэслэн боловсруулж, уг төслийг санхүүжүүлэх гэрээг 2016 онд Швейцарийн хөгжлийн агентлагтай байгуулав. 2016 оны 10-р сард уг төслийг албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд шинээр батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ.

Улс орон, дэлхий дахинаа санхүүжилтын орчинд гарч буй эдийн засгийн хүндрэл, өөрчлөлтүүдээс үл хамааран Монгол дахь НҮБ-ын Хүн амын сан тус сангийн тэргүүлэх чиглэлийг дэмжиж, Монголын хамгийн эмзэг бүлгийнхэнд үйлчилгээг хүргэх нэмэлт санхүүжилтыг амжилттай дайчлав. Зуданд өртсөн эмэгтэй малчдыг дэмжих төсөл боловсруулж, Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын нэгдсэн сангаас 492,000 ам.доллар дайчиллаа. Уг санхүүжилтыг ашиглан НҮБ-ын Хүн амын сан 3 сар гаруй хугацаанд 6 аймгийн 69 сумын 6,243 малчин өрхийн 11,702 охид, эмэгтэйчүүдэд тусламж үзүүлэв. Мөн 6 аймгийн 69 сумын жирэмсэн болон дөнгөж амаржсан 1,333 эхэд явуулын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж, жирэмсэн эмэгтэйчүүдийн 10.6%-д нь жирэмсний хүндрэлийн шинж тэмдэг илэрсэн тул мэргэжлийн эмч нарын хяналтад эмчлүүлж, амаржуулахаар аймаг, сумын эмнэлэгт хүргэв. Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын нэгдсэн сангийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан жирэмсэн, дөнгөж амаржсан эмэгтэйчүүдийг оруулан нийт 13,035 эмэгтэйд хүрч үйлчлэв.

Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын нэгдсэн сангийн дэмжлэгтэйгээр ариун цэвэр, эрүүл ахуйн багц хүлээж авсан малчид НҮБ-ын Хүн амын сан руу утасдаж, талархалаа илэрхийлж байв. Үүний дараа орон нутагт томилолтоор ажиллах үед хийсэн ажиглалтаас үзвэл ариун цэвэр, эрүүл ахуйн багцад орсон бүтээгдэхүүнүүд бүгд чанар сайтай байснаас гадна тэднийг бүрэн бүтэн түгээснийг тусламж хүлээж авсан эмэгтэйчүүд нотлов.

Эх, нярайн эрүүл мэндийг дэмжих Телемедицин төслийн үр дүнг нэгтгэж, тогтвортой байдлыг нь хангахаар 2019 оны 2 сарын 17 хүртэл төслийн эцсийн шатлалыг хэрэгжүүлэхээр Люксембургийн Засгийн газартай тохиролцов. Төслийн эцсийн шатлалыг 1,8 сая ам.доллараар санхүүжүүлэхээ Люксембург мэдэгдсэн юм.



## **НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ болон улс орныг дэмжих 6 дахь хөтөлбөр**

2017-2021 онд хэрэгжүүлэх НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээг 2016 оны 9-р сард Гадаад харилцааны яамтай үзэглэв. Уг тусламжийн хүрээг боловсруулахад НҮБ-ын Хүн амын сан идэвхитэй оролцож, олон нийтийн дуу хоолой, тайлагнах зарчмыг бэхжүүлэх тухай үр дүнгийн 3 дахь чиглэлийг боловсруулах ажлын хэсгийг ахалсан юм.

Мөн Монгол улсад дэмжлэг үзүүлэх НҮБ-ын Хүн амын сангийн 6 дахь хөтөлбөрийг эцэслэж, 2016 оны 9-р сард Захирлуудын зөвлөл батлав. Энэхүү 6 дахь хөтөлбөр нь 2017-2021 онд хэрэгжүүлэх НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд бүрэн тусгагдсан бөгөөд уг тусламжийн хүрээг хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнүүдийг боловсруулах гэж байна. 6 дахь хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Хүн амын сан залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хангах, залуучуудыг эрх мэдэлжүүлж, оролцоог хангах, жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхэд гол анхарлаа хандуулж, энэ чиглэлийн бодлого боловсруулах, ухуулга нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## **Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусав**

Улс орныг дэмжих 5 дахь хөтөлбөрийг дуусгавар болгож, дүгнэх уулзалтыг 2016 оны 12-р сард зохион байгуулсан бөгөөд энэхүү хөтөлбөр нь бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, залуучуудын хөгжил, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийг хангахад ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Уг хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Хүн амын сан Залуучуудын хөгжлийн 16 төв, өсвөр үе, залуучуудад ээлтэй 21 клиник, нэг цэгийн үйлчилгээний 6 төв болон эх, нярайн эрүүл мэндийг дэмжих телемедицин сүлжээг улс орон даяар байгуулав.

5 дахь хөтөлбөрийнхөө хүрээнд НҮБ-ын Хүн амын сан Монгол Улсын Засгийн газарт техник арга зүй, санхүүгийн томоохон дэмжлэг үзүүлж, бодлого, зохицуулалтын орчинг залуучууд, эмэгтэйчүүдэд ээлтэй болгов. 2014 онд хийсэн хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээнд үндэслэн хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах замаар 5 дахь хөтөлбөрийн хүрээнд доод шатанд үзүүлж байсан тусламж дэмжлэгийг дээш бодлогод чиглэсэн дэмжлэг болгож амжилттай өөрчлөв.

## **Захиргаа, санхүүгийн үр ашигтай үйл ажиллагаа**

2016 онд захиргаа, санхүүгийн үйл ажиллагаа илүү оновчтой, шуурхай боллоо. НҮБ-ын Хүн амын сантай хамтран ажиллагч түнш байгууллагуудад зориулж сургалт зохион байгуулсанаар тэд тус сангийн дүрэм, журмыг улам чанд дагаж, мөрдөх болж, НҮБ-ын Хүн амын сангийн төв удирдлагаас жил бүр хийлгэдэг аудитад бэлтгэх явдал сайжирсан байна.

НҮБ-ын Хүн амын сан шуурхай арга хэмжээ авч, жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэлийн тасалдлыг яаралтай шийдвэрлэхээр нөөц хөрөнгө хуваарилав. Дөрвөн 7 хоногийн дотор НҮБ-ын Хүн амын сан нөхцөл байдлыг үнэлж, ЭМЯ-тай хамтран стратегиа боловсруулж, нөөц 100, 000 ам.долларыг бүрдүүлэв. Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэлийн нөөц багассан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч чухал цэгүүдэд жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл худалдан авахад НҮБ-ын Хүн амын сан уг хөрөнгийг дайчлав. Үүгээр Монгол улсын жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэлийн 8 сарын хэрэгцээг хангахаар тооцоолж байна.

НҮБ-ын хамтарсан үйл ажиллагаанууд нь шат дамжлага багатай хэрнээ илүү их үр дүнтэй байлаа. НҮБ-ын Хүн амын сан НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллаж, хангалт, үйлчилгээний худалдан авалтаа хамтран хийж, шат дамжлагуудыг нэгтгэж, ажиллав. Энэ нь уг ажиллагаанд оролцсон бүх байгууллагуудын захиргааны үр ашгийг нэмэгдүүлэв.

## Нэгдмэл дуу хоолой

Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газрын ажилтнууд 2016 онд тус сангийн Нэгдмэл дуу хоолойгоор ажиллацгаая хөтөлбөрт оролцож, сургалтад хамрагдав. Өөр хоорондоо харилцаж багаар ажиллах энэхүү сургалт нь ажилтан бүрийг дэлхий дахинаа НҮБ-ын Хүн амын сангаас хэрэгжүүлж буй хүчин чармайлтыг дагаж, Монголын нөхцөлд нэвтрүүлэх чадавхитай болгож, улмаар НҮБ-ын Хүн амын санг нэгдмэл дуу хоолойгоор харилцдаг байгууллага болгох зорилготой байв. Тухайн ажилтан нь хөтөлбөр, захиргаа санхүү, хүний нөөц, хэвлэл харилцааны хэсэгт ажилладагаас үл хамааран НҮБ-ын Хүн амын сангийн стратеги төлөвлөгөөнд заасан тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэдэг болохыг уг хөтөлбөрт онцолдог. НҮБ-ын Хүн амын сангийн Ази, номхон далайн бүсийн хэвлэл мэдээлэл, харилцааны зөвлөх Бангкокоос ирж уг хоёр өдрийн сургалтыг чиглүүлж, Монгол дахь тус сангийн суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудыг бүх түвшинд үйл ажиллагаагаа дэлхийн түвшинд нийцүүлж, үр дүнг нь тодорхой илэрхийлдэг болоход туслав.



# 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН

## НӨӨЦИЙН ХУВААРИЛАЛТ, ЗАРДАЛ (АМ.ДОЛЛАР)

ЭХ ҮҮСВЭР	ТӨСӨВ	ЗАРДАЛ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
Тогтмол эх үүсвэр	1,159,063	1,157,050	2,013	100%
Бусад эх үүсвэр	2,928,244	2,698,015	230,228	92%
Суурин төлөөлөгчийн газрын төсөв	460,938	449,424	11,514	98%
<b>БҮГД</b>	<b>4,548,245</b>	<b>4,304,489</b>	<b>243,755</b>	<b>95%</b>

## ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ (БУСАД ЭХ ҮҮСВЭР)

ХАНДИВЛАГЧ	ТӨСӨВ	ЗАРДАЛ	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
Швейцарийн хөгжлийн агентлаг (залуучуудын хөгжил)	1,165,471	1,070,931	94,540	92%
Швейцарийн хөгжлийн агентлаг (жендэрт суурилсан хүчирхийлэл)	216,547	129,355	87,192	60%
Люксембургийн Засгийн Газар (Телемедицин)	888,327	855,492	32,835	96%
Люксембургийн Засгийн Газар (БЗДХ)	168,809	166,605	2,204	99%
Онцгой байдлын үед зарцуулах НҮБ-ын нэгдсэн сан	446,851	443,513	3,338	99%
Оюу толгой ХХК	41,693	31,648	10,044	76%
Дотоодын хандив	547	473	74	86%
<b>БҮГД</b>	<b>2,928,244</b>	<b>2,698,016</b>	<b>230,228</b>	<b>92%</b>



<b>ЗАРДАЛ, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГЭЭР</b>			
	<b>ТОГТМОЛ ЭХ ҮҮСВЭР, БОЛОН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТӨСӨВ</b>	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>БҮХ ЗАРДАЛ, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГЭЭР</b>
Жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл	278,617	573,340	851,957
Хүн ам ба хөгжил	239,588	10,090	249,677
Залуучууд	212,559	1,083,056	1,295,615
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд	302,086	1,031,529	1,333,615
Хөтөлбөрийн зохицуулалт	124,200	–	124,200
Суурин төлөөлөгчийн газрын төсөв	449,424		449,424
<b>БҮГД</b>	<b>1,606,474</b>	<b>2,698,015</b>	<b>4,304,489</b>

**НИЙТ ЗАРДАЛ, БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГЭЭР**

